



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1/49

Мөрөн сум

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
хаврын дархлаажуулалтын ажлын зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6, 9 дугаар зүйлийн 9.1-9.9, 28 дугаар зүйлийн 28.4 дах хэсэг. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг сумын бүх үхэр, гахайг хамруулан 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгүүлэх, уг ажлын явц, чанарт хяналт тавьж ажиллах сумын Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Малчдад урдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бариулах, дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг Тамгын дарга (Н.Намжилноров)-д, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтад шаардагдах вакцин мэргэжлийн удирдлага, заавар зөвлөмжөөр хангах, дархлаажуулалтын явц, технолги, гүйцэтгэлт хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жавхлантөгс)-д, технологит хугацаанд нь мал үлдээлгүй дархлаажуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-д тус тус даалгасугай.

ДАРГА

Н.ХАТАНБААТАР